

- b. Гишүүнбайгууллагуудад өөрийн хариуцсан чиглэлээр сургалт зохионбайгуулах, Төлөвлөгөөтажлынгүйцэтгэлд нь зөвлөгөө, дэмжлэгтулалцаа үзүүлэх;
- c. Хариуцсан чиглэл болон гишүүн байгууллага хоорондын харилцаа холбоо, хамтынажиллагааг хамгийн үр дүнтэй байлгах бүх талын арга хэмжээг авчажиллах;
- d. Олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг хариуцсан чиглэлийн дагуусурталчилж, таниулах ажлуудыг хийж хамтран ажиллах зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэнэ.

5.33. Холбооны Дэд ерөнхийлөгч жилд **5,000,000 /таван сая/-аас** доошгүй төгрөгийг холбооны үйл ажиллагааны зардалд зориулан дэмжлэг хэлбэрээр оруулна.

**Ерөнхий нарийн бичгийн дарга**

- 5.34. Ерөнхий нарийн бичгийн дарга нь уулынспортыг хөгжүүлэх чин эрмэлзлэлтэй, дээд боловсролтой, гадаад хэлний зохих мэдлэгтэй, гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харьцах харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвар, туршлага бүхий ял шийтгэлгүй Монгол Улсын иргэн байна.
- 5.35. Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Удирдах зөвлөл сонгоно.
- 5.36. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбооны удирдах зөвлөлийн гишүүн байж болно.
- 5.37. Ерөнхий нарийн бичгийн дарга нь энэ дүрэм болон Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 5.38. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 5.38.1. Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Холбооны өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл хийх, Холбоог төлөөлөн өдөр тутмын ажлыг гүйцэтгэх;
  - 5.38.2. Гэрээнд заасан бусад бүрэн эрх.
- 5.39. Ерөнхий нарийн бичгийн даргын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 5.40. Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа дууссан тохиолдолд удирдах зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол шинээр Ерөнхий нарийн бичгийн дарга томилогдтол албан үүргээ хэвээр гүйцэтгэнэ.
- 5.41. Ерөнхий нарийн бичгийн дарга нь өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

**Хяналтын зөвлөл**

- 5.42. Хяналтын зөвлөл нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээрийг бүх гишүүдийн хурлаас томилно. Хяналтын зөвлөлийн даргыг хяналтын зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно
- 5.43. Хяналтын зөвлөл нь Холбооны дүрэм, бүх гишүүдийн хурлын болон удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, Холбооны удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж бүх гишүүдийн хуралд танилцуулах

